




# Булангийн чулуу сургалт



Ашиглах нөхцөл (2021 оны 13-р сарын 4-нд шинэчлэгдсэн) Хувийн мэдээлэл хадгалах тухай  
мэдэгдэл (2021 оны 6-р сарын 4-нд шинэчлэгдсэн)

© 2021 Intellectual Reserve, Inc. Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

Суурийн чулуу анги: Мэндчилгээ ба үр дүн



## МЭНДЧИЛГЭЭ

Институтийн Суурийн чулуу цуврал хичээлд тавтай морилно уу! Есүс Христэд болон Түүний сэргээгдсэн сайн мэдээнд гүн гүнзгий хөрвөгдөхөд нь суралцагчдадаа туслах энэхүү боломжийг хүлээн авсанд тань баярлалаа.

## ЗААХЫН ӨМНӨ


Заахаасаа өмнө та дараах зүйлсийг хийсэн байвал зохино. Үүнд:

- Суурийн чулуу цуврал хичээлийг заах [Товч удирдамж](#)-ийг дахин уншина уу.
- [Багшийн материал](#)-ын оршлыг анхааралтай судал.
- Ажил үүрэг, суралцагч, хичээл, аливаа асуултынхаа талаар зохицуулагч, институтийн захиралтайгаа ярилцахаар цаг товлон уулз.
- Суралцагчдадаа Христэд ирж, Түүнтэй илүү адилхан болоход нь туслахын тулд удирдамж заавар авахыг хүсэн залбир.

## ДОТООД СУРГАЛТЫН ЗОРИЛТ


Үр дүнтэй заахад чухал олон зарчим, ур чадвар бий. Та үргэлжлүүлэн институт, семинарын гарын авлагад заасан зарчмуудыг судалж, ур чадвараар дасгал хийж болно. Энэхүү дотоод сургалтын хүрээнд цуврал хичээл болон хөтөлбөрт тань чиг баримжаа өгч туслах үүднээс институтийн Суурийн чулуу цуврал

хичээлийг заахтай холбоотой хэдэн чухал ур чадварыг тодорхойлж, загвар гарган, дасгал хийлгэнэ. Аврагч Есүс Христтэй адил болоход нь суралцагчдад туслахын тулд бэлтгэх, оролцох, үйлдэх зэрэгт тэдэнд дэмжлэг үзүүлэхийг эрэлхийлж, мөн тэдэнд сурган зааж, сургаалд хөрвөгдөх туршлагыг өгөхөд тань эдгээр ур чадвар тусална.




- **Бэлтгэх:** Урилгаар дамжуулан суралцагчийн бэлтгэлийг сайжруулах
- **Идэвхтэй оролцуулах:** Суралцагчдыг бэлтгэл дээр суурилан идэвхтэй оролцуулах
- **Үйлдэх:** Амьдралд хэрэгжүүлэхийг онцлох

Урих замаар суралцагчийн бэлтгэлийг сайжруулах



## *УР ЧАДВАР: УРИХ ЗАМААР СУРАЛЦАГЧИЙН БЭЛТГЭЛИЙГ САЙЖРУУЛАХ*

Та суралцагчдын хичээл дээрх туршлагыг чанаржуулахын тулд тэдний бэлтгэлийг хэрхэн сайжруулах вэ?



**Эдгээр хэсгийг уншиж, зааварчилгааг дага. Сурч байгаа зүйлээ хэлэлцүүлгийн самбарт бичиж тэмдэглэ.**



## ТОДОРХОЙЛОХ

Суурийн чулуу цуврал хичээлийн Хичээлд бэлтгэх материалыг та болон таны суралцагчид хичээлд бэлтгэх явцдаа судлахад зориулсан болно. Бэлтгэх материалд хичээл дээр болон хичээлээс гадуур сургалтаа гүнзгийрүүлэхэд туслах асуулт, үйл ажиллагаануудаар дамжуулан багш, суралцагч хоёрыг хичээлийн бэлтгэлээ сайжруулах урилгууд орсон байдаг. Эдгээр урилга тус бүр нь эдгээр урилгыг хэрхэн, хэзээ хэрэглэх мөн хэрхэн хичээлд ашиглаж болохыг харахад туслах шигтгээ зурагтай.



## ЗАГВАР

Хичээлийн хөтөлбөр дээрх бэлтгэх урилгуудын хэдэн жишээг дурдъя. Үүнд:



Хичээлд бэлтгэхээр тунгаан бодох

Жишээ: “Мормоны Ном бол Бурханы үг гэдгийг мэдэхэд ямар ямар туршлага танд тусалсан бэ?”



Хичээлд бэлтгэхээр судлах

Жишээ: “Бошиглогч Алма Аврагчийн Цагаатгалын тухай хүмүүст заасан. Алма 7:11-13-ыг уншина уу.”



Төрсөн сэтгэгдлээ бичиж тэмдэглэ

Жишээ нь: “Тэмдэглэл дээрээ эсвэл доорх зайд энэ хэсгийн судрын эшлэл, сургаалуудаас өөрт онцгой санагдсан хэдэн үнэнийг болон өөрт байгаа бусад бодол санаа, асуултаа бичнэ үү. Тодорхойлсон үнэн, аливаа ойлголтоо ангид хуваалцахаар бэлтгэж ир.”



### Хичээлд бэлтгэхээр хэлэлцэх

Жишээ нь: “Гэр бүлийн гишүүн эсвэл найзынхаа тусламжтайгаар эдгээр шүлгээс олж мэдсэн зарчмуудыг өнөө үед хэрхэн амьдралд хэрэгжүүлж байгаа зарим туршлагыг тодорхойл. Сурч мэдсэн зүйлээ ангидаа хуваалцахаар бэлтгэж ир.”



### Сурсан зүйлээ үйлдэл болгох

Жишээ нь: “Та бусдад Есүс Христийн адил үйлчлэхийн тулд ирэх өдөр, долоо хоногуудад юу юу хийх вэ?”

Хичээлийн хөтөлбөр хэрхэн урих замаар суралцагчийн бэлтгэлийг сайжруулдгийг одоо та харсан тул хөтөлбөр дэх эдгээр урилгыг олж, ашиглаж сурах дасгал хий.



### ДАСГАЛ ХИЙХ

Суралцагчдын бэлтгэлийг сайжруулахын тулд эдгээр урилгыг хайж, ашиглаж сурах дасгалыг дараах алхмуудыг дагуу хийнэ үү.

1. Багшийн материал дээрх одоо зааж буй болон заах гэж байгаа хичээл рүүгээ очин, тэнд толилуулсан бэлтгэх урилгуудыг хар.
2. Эдгээр урилгаас нэгийг нь сонго.
3. Суралцагчийг бэлтгэх үед энэ үйл ажиллагаа ямар байх талаар бодож үз. Энэхүү бэлтгэх урилгыг ашиглах нь хичээлийн өмнө болон хичээлийн туршид авах суралцагчийн туршлагад үзүүлэх нөлөөний тухай бод. Та эдгээр бэлтгэх урилгыг тодорхойлж сурахад суралцагчдад тусалснаар тэднийг дараагийн хичээлд бэлтгэхэд хэрхэн урьж болох талаар бодож үз.
4. Өөр бэлтгэх урилгыг олж тогтоон, энэ дасгалыг давт.

Бэлтгэх урилгыг сайн мэддэг, үр дүнтэй ашигладаг болох нь суралцагчдадаа анхаарлаа төвлөрүүлж, гүн гүнзгий суралцах туршлага олж авах бэлтгэлийг нь сайжруулахад танд тусална.





## ОРУУЛАН АШИГЛАХ

Урих замаар суралцагчийн бэлтгэлийг сайжруулахаар ажиллахдаа дараах асуултуудыг бодож үзнэ үү. Үүнд:

- Та эдгээр дасгал ажлаас сурч мэдсэн зүйлээ хэрхэн хичээлдээ оруулан ашиглаж болох вэ?
- Багшийн хувьд өсөж хөгжихийн тулд энэ ур чадвар дээр үргэлжлүүлэн ажиллахын тулд та юу хийж болох вэ?



## ХЭЛЭЛЦЭХ


Энэ туршлагаас сурч мэдсэн зүйлээ доорх хэлэлцүүлгийн самбарт бичиж тэмдэглэ. Бусад хүн юу сурч, юу хийж байгааг харахын тулд тэдний бичсэн зүйлийг уншихад анхаар.

Бэлтгэл дээр нь суурилан суралцагчдыг идэвхтэй оролцуулах



## УР ЧАДВАР: БЭЛТГЭЛ ДЭЭР НЬ СУУРИЛАН СУРАЛЦАГЧДЫГ ИДЭВХТЭЙ ОРОЛЦУУЛАХ

Та хичээлд бэлтгэх явцдаа суралцагчдын сурсан, олж мэдсэн, мэдэрсэн зүйл дээр нь суурилан суралцагчдыг хэрхэн хичээлд идэвхтэй оролцуулах вэ?





*Дараах хэсгүүдийг уншиж, зааврыг дага. Сурч байгаа зүйлээ хэлэлцүүлгийн самбарт бичиж тэмдэглэ.*



## ТОДОРХОЙЛОХ

Суурийн чулуу цуврал хичээлийн туршид сургалтын хөтөлбөр нь суралцагчдынхаа бэлтгэлд итгэж, үүнд дээр нь суурилан заахад танд тусална. Багшийн материалд “эргэн харах,” “сэргээн санах,” “холбох,” “бэлтгэлээсээ хуваалцах” гэх мэт суралцагчдыг урих замаар идэвхтэй оролцуулах олон сануулга орсон байдаг бөгөөд эдгээр нь ангийн туршлагыг чиглүүлэхэд суралцагчдын ойлголт, бэлтгэлийг ашиглахыг танд сануулж, урамшуулдаг.



## ЗАГВАР

Хичээлийн хөтөлбөрөөс олж болох идэвхтэй оролцуулах сануулгын хэдэн жишээг дурдъя. Үүнд:

- “Хичээлд бэлтгэх явцаас энэ нөхцөл байдлын талаар санаж байгаа зүйлээ ярьж өгөхөд суралцагчдыг урь.”
- “Бэлтгэх материалд онцгой санагдсан үнэнүүдээ тэмдэглэхэд тэднийг урьсныг суралцагчдад сануул. Энэ хэсэгт зурж тэмдэглэсэн судрын эшлэл, бошиглолын сургаалуудаа эргэн харах хугацааг суралцагчдад гаргаж өг. Олж мэдсэн зүйлээ ангийнхантайгаа хуваалцахыг тэднээс хүс.”
- “Хичээлд бэлтгэх явцад сурч мэдсэн зүйлээ найздаа туслахын тулд хэрхэн ашиглах талаар жижиг бүлгүүдэд хуваагдан ярилцах хэдэн минут суралцагчдад өг.”

Хичээлийн хөтөлбөр хэрхэн суралцагчийн бэлтгэл дээр суурилахад тусалдгийг та харсан тул хөтөлбөр дээрх идэвхтэй оролцуулах эдгээр сануулгыг хайж олох дадлага хий.



## ДАДЛАГА ХИЙХ

Суралцагчийн бэлтгэл дээр суурилан идэвхтэй оролцуулах сануулгыг олж, ашиглаж сурах дасгалыг дараах алхмуудын дагуу хийнэ үү.

1. Багшийн материал дээрх одоо зааж буй болон заах гэж байгаа хичээл рүүгээ очин, тэнд толилуулсан идэвхтэй оролцуулах сануулгуудыг хар.
2. Тэдгээр сануулгаас нэгийг нь сонго.
3. Ангид энэ үйл ажиллагааг явуулбал ямар байх талаар бодож үз. Энэхүү идэвхтэй оролцуулах сануулгыг ашигласнаар суралцагчийн туршлагад үзүүлэх нөлөөний тухай бод.
4. Идэвхтэй оролцуулах сануулгыг тодорхойлж, энэ дасгалыг давтан хий.

Идэвхтэй оролцуулах сануулгыг сайн мэддэг, үр дүнтэй ашигладаг болох нь суралцагчдадаа анхаарлаа төвлөрүүлж, гүн гүнзгий суралцах туршлагад идэвхтэй оролцуулахад тань тусална.



## ОРУУЛАН АШИГЛАХ

Та суралцагчдын бэлтгэл дээр суурилан ангийн оролцоог нэмэгдүүлэх тал дээр ажиллах явцдаа дараах асуултуудыг харгалзан үзнэ үү. Үүнд:

- Та зааж байхдаа эдгээр дасгалаас сурч мэдсэн зүйлээ хэрхэн оруулан ашиглах вэ?
- Багшийн хувьд өсөж хөгжихийн тулд энэ ур чадвар дээр үргэлжлүүлэн ажиллахын тулд та юу хийж болох вэ?



## ХЭЛЭЛЦЭХ


Энэ туршлагаас сурч мэдсэн зүйлээ доорх хэлэлцүүлгийн самбарт бичиж тэмдэглэ. Бусад хүний юу сурч, юу хийж байгааг харахын тулд тэдний бичсэн зүйлийг уншсан байхад анхаар.

## Амьдралд хэрэгжүүлэхийг онцлох



## УР ЧАДВАР: АМЬДРАЛД ХЭРЭГЖҮҮЛЭХИЙГ ОНЦЛОХ

Та ангидаа амьдралд хэрэгжүүлэхийг хэрхэн онцлох вэ? Та суралцагчдыг сурч мэдсэн зүйлийнхээ дагуу үйлдэхэд урамшуулахын тулд юуг хийх вэ?



**Эдгээр хэсгийг уншиж, зааварчилгааг дага. Сурч байгаа зүйлээ хэлэлцүүлгийн самбарт бичиж тэмдэглэ.**



## ТОДОРХОЙЛОХ

Суралцагч, багш нар хичээлийн өмнө үр дүнтэй бэлдэж ирвэл, хичээл дээр олж мэдэх үнэнүүдийнхээ дагуу амьдрах арга замаа тодорхойлоход нь суралцагчдад туслах цаг ангид илүү их гарна. Багшийн материал нь суралцагчийн бэлтгэл дээр суурилан зааж, Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёртой илүү адил болоход нь туслах арга замаар үйлдэх хүч, чадавхыг өсгөхөд туслах зорилготой.



## ЗАГВАР

Суурийн чулуу ангийн хөтөлбөрөөс олж болох амьдралд хэрэгжүүлэх тухай хэлэлцүүлэг, урилгуудаас хэдэн жишээг дурдъя. Үүнд:

- “Дараах асуултуудыг суралцагчдад тавь: Та болон таны гэр бүлийнхэн гэр бүлийн түүхийн ажил, ариун сүмийн үйлчлэлд ямар ямар арга замаар оролцож байсан бэ? Та энэ ажилд оролцсоноор ямар ямар адислал авч байсан бэ? Та гэр бүлийн түүхийн ажлаа хийхэд нь зааж, зөвлөж чадах хэн нэгнийг бодоход суралцагчдыг урьж болно. Хэрэв зарим суралцагч гэр бүлийн түүхээ аль хэдийн хийж сурсан бол ангийнхаа өөр хэн нэгэнд зааж сургахад тэднийг урь.”
- “Суралцагчдад дараах асуултыг эргэцүүлж, бодол санаагаа бичиж тэмдэглэх цаг өг. Би ямар арга замаар Сүмд болон Сүмийн зорилгуудыг гүйцэлдүүлэхэд илүү идэвхтэй тусалж чадах вэ?”
- “Дараах асуултыг үзүүл: Би Есүс Христийн хүчийг амьдралдаа илүү бүрэн дүүрэн урьж авчрахын тулд юу хийх вэ? Энэ асуултыг залбирч тунгаан бодоод, хариултаа тэмдэглэлийн дэвтэртээ бичиж тэмдэглэх цаг суралцагчдад гаргаж өг. Тэднийг тунгаан бодож байх үед Аврагчийн хүчийг тодорхой арга замаар амьдралдаа урин авчрахыг урамшуулан дэмжсэн хожмын үеийн бошиглогчийн эшлэлийг үзүүлэхийг бод.”

Хичээлийн хөтөлбөр хэрхэн амьдралд хэрэгжүүлэхийг суралцагчдад онцлоход тусалдгийг та одоо харсан учраас хөтөлбөрийн заах үйл ажиллагаануудаар дасгал хий.



Амьдралд хэрэгжүүлэхийг суралцагчид онцлохын тулд заах үйл ажиллагаануудыг хэрхэн олж, ашиглах дасгалыг дараах алхмуудын дагуу хийнэ үү.

1. Багшийн материал дээрх одоо зааж буй болон заах гэж байгаа хичээл рүүгээ очин, тэнд толилуулсан заах үйл ажиллагаануудыг хар.
2. Эдгээр заах үйл ажиллагаанаас нэгийг сонгож, амьдралд хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа, асуултуудыг анхааралтай унш.
3. Энэ заах үйл ажиллагаа болон тавьсан асуултууд суралцагчийн туршлагад ямар нөлөө үзүүлэх тухай бод.
4. Багшийн материал дээрх өөр хичээлийг сонгон, амьдралдаа хэрэгжүүлэхийг онцлоход туслах заах үйл ажиллагаануудыг тодорхойлон энэ үйл ажиллагааг давтан хий.

Амьдралд хэрэгжүүлэх тухай хэлэлцүүлгүүдийг сайн мэддэг, үр дүнтэй ашигладаг болж сурах нь суралцагчдадаа анхаарлаа төвлөрүүлж, Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёртой илүү адилхан болоход нь танд тусална.



Суралцагчдаа урамшуулж, амьдралд хэрэгжүүлэхийг онцлохдоо дараах асуултуудыг бодож үз. Бодол санаагаа доорх хэлэлцүүлгийн самбарт бичиж тэмдэглэ.

- Та эдгээр үйл ажиллагаанаас сурч мэдсэн зүйлээ хэрхэн хичээлдээ оруулан ашиглаж болох вэ?
- Багшийн хувьд өсөж хөгжихийн тулд энэ ур чадвар дээр үргэлжлүүлэн ажиллахын тулд та юу хийж болох вэ?





Энэ туршлагаас сурч мэдсэн зүйлээ доорх хэлэлцүүлгийн самбарт бичиж тэмдэглэ. Бусад хүн юу сурч, юу хийж байгааг харахын тулд тэдний бичсэн зүйлийг уншихад анхаар.

Дүгнэлт

## ДҮГНЭЛТ

Есүс Христэд болон Түүний сэргээгдсэн сайн мэдээнд гүн гүнзгий хөрвөгдөхөд суралцагчдадаа туслах энэхүү ажлыг хүлээн авсанд тань баярлалаа.

### САНА:

- Христэд ирж, Түүнтэй илүү адил болоход нь суралцагчдадаа туслахыг эрэлхийлэх үед Их Эзэн таныг удирдан чиглүүлэх болно.
- Асуулт, асуудал байвал зохицуулагч эсвэл институтийн захирал тань танд тусална.
- Энэхүү сургалтад тодорхойлсон, загварчилсан, дасгал болгон оруулсан ур чадварууд нь суралцагчдаа адислахын тулд сургалтын хөтөлбөрөө илүү үр дүнтэй ашиглаж сурахад тусалж чадна. Суралцагчдадаа Аврагч Есүс Христтэй илүү адилхан болоход нь туслахаар бэлтгэж, оролцож, үйлдэхэд нь дэмжлэг үзүүлэхийг эрэлхийлэх үед тань эдгээр ур чадвар сэнхрүүлж, хөрвүүлэх туршлагыг тэдэнд өгөхөд танд тусална.

